

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Л. Сэдбазар	Дугаар	1366
Оршин суугаа аймаг	Өвөрхангай аймгийн	Оршин суугаа сум	Есөнзүйл сум
Төрсөн газар		Төрсөн он	1913
Ажил мэргэжил			
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Далай гүний хүрээ (Далай вангийн хүрээ, Жонон гүний хүрээ)	Сүм хийдийн дугаар	ӨХЕЗ 005
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р	Ярилцлага авсан хүн	М.Жужа, Т.Кристина, О.Энхбаяр



Өвөрхангай аймаг, Хойд хүрээ

Жужа: Хэдэн настай байхдаа лам болсон бэ?

Сэдбазар: Арван наснаасаа хойш лам байсан.

Жужа: Аль хийдэд шавилан сууж байсан бэ?

Сэдбазар: Энэ хойд хийд дээр сууж байсан юм даа.

Жужа: Тэр хийд хэзээ байгуулагдсан бэ?

Сэдбазар: Тэрийг нас гүйцэж яаж мэдэхэв дээ.

Жужа: Тэр үед хэдэн ламтай байсан бэ?

Сэдбазар: 1000-аад ламтай байсан.

Жужа: Хэдэн дуган байсан бэ, ямар ямар дуган байсан бэ?

Сэдбазар: Найман дуган. Чогийн дацан, хойд дуган, цогчин дуган.

Жужа: Чойр дацан байсан уу?

Сэдбазар: Чойр байгаагүй. Жүдтэй байсан юм.

Жужа: Энэ хийдийн тэргүүн лам ямар цолтой хүн байсан бэ?

Энхбаяр: Яг тэр таны сууж байсан үеийн хамба лам нь эсвэл хамгийн сүүлийн хамба лам нь?

Сэдбазар: Цорж багш гэж байсан юм аа. Түвдэн гэдэг байсан юм.

Жужа: Хутагт хувилгаан лам байсан уу?

Сэдбазар: Байсан.

Жужа: Ямар нэртэй хүн бэ?

Сэдбазар: Чимэддорж гэж нэртэй хүн байсан.

Жужа: Дуганууд юугаар хийсэн байсан бэ?

Сэдбазар: Тоосго.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Дуганууд хоёр давхар байсан уу, дан байсан уу?

Сэдбазар: Хоёр давхартай дуган хоёр л байсан.

Жужа: Аль аль дуган?

Сэдбазар: Цогчин дуган, сүмийн дуган.

Жужа: Хүрээнд цам бүжиг гардаг байсан уу?

Сэдбазар: Хийдэг байсан.

Жужа: Яг хэзээ гардаг байсан бэ?

Сэдбазар: Цагаан сараар л гарна даа.

Жужа: Хэд орчим баг гардаг байсан бэ, хэдэн лам?

Сэдбазар: Чухам хэдийг мэдэхгүй байна. Олон л хүн байсан.

Жужа: Майдар эргэдэг байсан уу?

Сэдбазар: Эргэнэ.

Жужа: Хаврын үеэр үү, зуны үеэр үү?

Сэдбазар: Хавар эргэдэг байсан юм. Чи чинь аль орчмын хүн байна?

Жужа: Би Унгар.Тэгээд энэ ганжуур бас эргэдэг байсан уу?

Сэдбазар: Байсан.

Жужа: Жилд нэг удаа юу?

Сэдбазар: Жилд нэг удаа хошуугаар эргэдэг байсан.

Жужа: Хайлан хурдаг байсан уу?

Сэдбазар: Хайлан хурна.

Жужа: Хайлан аль дуганд хурдаг байсан бэ?

Сэдбазар: Цогчин дуганд.

Жужа: Хэд орчим лам оролцох вэ?

Сэдбазар: Тэрний тоог мэдэхгүй дээ, олон л хүн байсан.

Жужа: Тэр хүрээ хэрэмтэй байсан уу?

Сэдбазар: Байгаа. Тоосгон хашаатай байсан юм.

Жужа: Суварга байсан уу? Хэдэн суварга байсан бэ?

Сэдбазар: Есөн суварга гэж байсан юм. Нэг том суварга, цоо шинэ жижигхэн суварга. Шинэ есөн суварга байсан юм.

Жужа: Хүрээний гол шүтээн сахиус ямар сахиус байсан бэ?

Сэдбазар: Чойжоо, махгал, гомбо байсан.

Жужа: Хүрээнд гавжийн дамжаа байсан уу?

Сэдбазар: Байсан.

Жужа: Ямар исчаатай байсан бэ?

Сэдбазар:Исчаа гэж би мэдэхгүй.

Жужа: Хүрээнд маарамбын дамжаа байсан уу?

Сэдбазар: Байсан.

Жужа: Аграмбын?

Сэдбазар: Аграмба ч байсан.

Жужа: Зийрэмбэ?

Сэдбазар: Байсан.

Жужа: Хүрээнд зоч лүйжинч лам нар байсан уу?

Сэдбазар: Байсан.

Жужа: Хүрээн дотор уу, гадна уу?

Сэдбазар: Хүрээнээс зүүн тийиш, тусгай дугантай байсан.

Жужа: Тэр хэд орчим зоч байсан бэ?

Сэдбазар: Тоог нь мэдэхгүй юм даа.

Жужа: Арав юм уу, зуу юм уу, их үү, цөөхөн үү?

Сэдбазар: 40, 50-иад байсан байх аа.

Жужа: Эмэгтэй лам хандмаа нар байсан уу?

Сэдбазар:Байсан.

Жужа: Хандмаа нар тусдаа дугантай байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэдбазар: Үгүй. Тэр цогчин дуганаас өөр дуган байгаагүй.

Жужа: Тэр цогчин дуганд хурдаг байсан уу, хандмаа нар?

Сэдбазар: Хааяа тэр цогчин дуганд хурдаг байсан юм.

Жужа: Нүгнээ хийдэг байсан уу?

Сэдбазар: Байсан, нүгнээ сахиx гэдэг юм.

Жужа: Тэгээд энэ бурхан багшийн дүйчэн өдрөөр хуралтай байсан уу?

Сэдбазар: Байлгүй яахав.

Жужа: Зулын хорин таванд?

Сэдбазар: Шинийн найман, арван таван, битүүн гээд...

Жужа: Ойрхон ямар нэгэн тахидаг овоо байсан уу?

Сэдбазар: Байсан.

Жужа: Ямар нэртэй овоо? Тахидаг овоо юм уу, рашаан?

Сэдбазар: Рашаан, овоо байсан юм.

Жужа: Төвдөөс лам нар ирсэн үү, Төвд лам их байсан уу?

Сэдбазар: Төвд лам их байгаагүй.

Жужа: Хүрээ хэдэн жастай байсан бэ?

Сэдбазар: Арван таван жастай байсан л байх.

Жужа: Энд өөр жижгхэн сүм хийдүүд байсан уу?

Сэдбазар: Байгаагүй, тэр цогчин хурлаас өөр.

Жужа: Богдын хүрээнээс лам нар ирдэг байсан уу?

Сэдбазар: Үгүй.

Жужа: Эрдэнэ зуу хийдээс?

Сэдбазар: Эрдэнэ зуугаас ирдэг байсан.

Жужа: Наймаачин хүмүүс байсан уу?

Сэдбазар: Ирдэг байсан юм гэнэ лээ.

Жужа: Энд амьдардаг байсан уу, ирдэг явдаг байсан уу?

Сэдбазар: Ирдэг явдаг байсан.

Жужа: Энэ хүрээний ойр орчимд борчууд байсан уу, хар хүн?

Сэдбазар: Борчууд байсан.

Жужа: Энэ дөрвөн аймаг ямар ямар нэртэй аймгууд байсан бэ?

Сэдбазар: Чойнхорлин, Дашлин, Шадавлин, Чойнлин ийм аймаг байсан юм даа. Дацан болохоор жүд, чойр, дүйнхор, ядам.

Жужа: Гүрмийн дацан байсан уу?

Сэдбазар: Гүрмийн дацан байсан.

Жужа: Мамбын дацан байсан биз?

Сэдбазар: Байсан.

Жужа: Та өөрөө энэ жүд дацанд хурдаг байсан уу?

Сэдбазар: Жүд дацанд.

Жужа: Тэр жүд дацан хэдэн ламтай байсан бэ?

Сэдбазар: 100-ад лам нар байсан байх аа.

Жужа: Энэ жүд дацангийн гол шүтээн сахиус ямар шүтээн сахиус байсан бэ?

Сэдбазар: Сандуй, дэмчиг...

Жужа: Энэ хийд ямар ганжууртай байсан бэ, ганжуур данжуур байсан уу?

Сэдбазар: Байсан. Чойнхор ганжуур байсан.

Жужа: Энэ нэр алдартай лам нар байсан уу, оточ, зурхайч?

Сэдбазар: Байсан.

Жужа: Ямар ямар байсан ?

Сэдбазар: Хамгийн түрүүнд Мэргэн хамба гэж байсан юм гэнэ лээ. Сайн нэр нь мартагдаад байна.

Жужа: Та хэдэн он хүртэл тэнд суусан, хэзээ хар болсон бэ?

Сэдбазар: Би 1915 оноос 1922 он хүртэл байсан юм.

Жужа: Дараагаар юу хийсэн бэ? Малчин болсон уу, цэрэгт явсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэдбазар: Цэрэгт яваагүй. Багийн дарга олон жил хийсэн.

Жужа: Хүрээ хэзээ хаагдсан бэ, хэдэн онд?

Сэдбазар: 1922 онд л хүрээ байхгүй болсон юм даа.

Жужа: Нураасан уу?

Сэдбазар: Нураасан. Нураагаад л зөөгөөд л , албаны улсууд ирээд л тэгээд л тараачихсан юм даа.

Жужа: Ямар нэгэн шүтээнийг нууцаар хамгаалсан уу?

Сэдбазар: Байхгүй, алга болсон. Хураалгаад л авчихсан.

Жужа: Хүрээний танаас өөр лам одоо бий юу, хүрээнд сууж байсан?

Сэдбазар: Байхгүй, үхэж гүйцсэн.

Жужа: Тэгээд энэ хийдийн байгуулалтын талаар ямар нэгэн түүх домог байгаа юу, хэн байгуулсан бэ?

Сэдбазар: Далай гүн гэж сүүлийн ноён байсан юм. Тэрнээс бусдыг нь би мэдэхгүй.

Жужа: Одоо энэ хүрээний туурь байгаа юу?

Сэдбазар: Бий.

Жужа: Харин дахин сэргээгүй, тийм ээ?

Сэдбазар: Үгүй, суварга л босгоод байгаа юм. Одоо эндээс хаашаа зүгт байна?

Жужа: Унгар баруун тийшээ...

Энхбаяр: Германтай ойрхон Европт байгаа.

Жужа: Эндээс 7000 км-т. Тэгээд энэ Есөн зүйлийн хурлын талаар та сонссон уу?

Сэдбазар: Юуны талаар гэнэ ээ?

Жужа: Есөн зүйлийн хурал юм уу, есөн зүйлийн суварга?

Сэдбазар: Есөн зүйл гэдэг чинь... уг нь манайх чинь Түшээт гүнийх.

Энхбаяр: Ямар хошуу байсан?

Сэдбазар: Далай гүний.

Жужа: Хүрээний дөрвөн аймаг яг аль аль зүгт байсан бэ?

Сэдбазар: Чойнхорлин нь баруун урд талдаа, Дашлин нь баруун хойд талдаа байсан юм. Шадавлин нь зүүн хойд талдаа.

Чойнхор нь зүүн өмнө талдаа байсан юм даа.

Жужа: Хүрээний цорж лам нар байсан уу?

Сэдбазар: Цорж гэж нэг л хүн байсан.

Жужа: Чойжин буудаг байсан уу?

Сэдбазар: Чойжин бууж байсан юм гэнэ лээ.

Жужа: Ярилцсанд их баярлалаа.

Сэдбазар: Зүгээр зүгээр.